210502	Хоол, хүнс	5,862,570.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.0
210604	Урсгал засвар	5,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,716,275.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,716,275.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,183,320.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,079,320.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,984,587.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,212,900.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,548,100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,156,800.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,508,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,771,687.0
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	12,471,787.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,299,900.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	226,659,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	226,659,600.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,226,140.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	202,593,465.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,839,995.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд татварын орлогын болон зээлийн авлагын мэдээ тайлан гаргалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 05/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянцогт сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Баянцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Баянцогт сумын ЗДТГ-ын даргын 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн № А/12 тоот тушаалаар зөвлөлийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлого 2,750,999.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 41,264.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 30,948.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлого 2,357,282.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 35,359.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 5,905.8 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 26,519.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянцогт сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагууд тусгай зориулалтын шилжүүлгээс 1,114,427.9 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвийн 777,599.9 мянган төгрөгийн санхүүжилт, Эрүүл мэндийн даатгалаас 14,272.4 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн хөгжлийн сангийн 57,924.9 мянган төгрөгийн санхүүжилт, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 35,351.9 мянган төгрөг, эмийн эргэлтийн сангийн борлуулалтын орлого 132,250.0 мянган төгрөг, нэмэлт Аудитын код ТӨА-2022/18/НА-СТА-ТТЗ

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

санхүүжилтийн дансанд 226,659.6 мянган төгрөг, нийт 2,358,486.6 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Баянцогт сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 08 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 44,648.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 50,723.2 мянган төгрөг, нийт 95,371.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 84,607.9 мянган төгрөг, татварын бус орлого 47,015.6 мянган төгрөг, нийт 131,623.5 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 36,252.3 мянган төгрөг буюу 138,0 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр 20,105.9 мянган төгрөг, хандиваар 290,983.7 мянган төгрөг, бусад байгууллагаас шилжүүлэн авсан болон дахин үнэлгээний нэмэгдэл 166,180.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй орлогоор 146,297.0 мянган төгрөг, нийт 623,566.9 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэсэн ба 41,258.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 371,938.8 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 240,492.3 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 5,638.6 мянган төгрөгийн, нийт 618,069.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 590,787.6 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 346,347.9 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах зээлийн авлага 274,612.0 мянган төгрөг, байгууллагаас авах авлага буюу Нийгмийн даатгалаас авах авлага 71,735.8 мянган төгрөг, нийт 346,347.8 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 274,612.0 мянган төгрөг буюу 79,3 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Ажилчидтай холбогдсон өглөг 620.5 мянган төгрөг, байгууллагад төлөх 9,705.7 мянган төгрөг нийт 10,326.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 213,562.6 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 61,947.5 мянган төгрөг нийт 275,510.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 167,397.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,637,324.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	136,084.8	275,510.1	(139,425.3)
Авлага	322,381.2	346,347.9	(23,966.7)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	140,940.0	168,222.2	(27,282.2)
Үндсэн хөрөнгө	3,253,861.4	3,637,324.2	(383,462.8)
Нийт хөрөнгө	3,853,267.4	4,427,404.4	(574,137.0)
Өр төлбөр	-	10,326.2	(10,326.2)
Засгийн газрын оролцоо	3,853,267.4	4,417,078.2	(563,810.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,853,267.4	4,427,404.4	(574,137.0)

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материалын дансны үлдэгдэл 168,222.2 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 27,282.2 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,637,324.2 мянган төгрөг болж 383,462.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд байшин хороололд дулааны шугам сүлжээ, 2 худаг шинээр гаргаж 94,456.0 мянган төгрөгийн их засвар, ЕБС-ийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалт 238,387.8 мянган төгрөгөөр, ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 56,740.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгийг дансанд бүртгэлд тусган, тайлагнаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,417,078.4 мянган төгрөг болж 563,810.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 2,221,305.3 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Баянцогт сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 08 дугаар тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 95,371.2 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 2,016,461.7 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 04 дугаарын тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2,042,875.3 мянган төгрөгөөр тодотгон баталж зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төслөөс 178,430.0 мянган төгрөгөөр бууруулан санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 8 хөтөлбөр арга хэмжээнд зориулан 1,905,900.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 56,315.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 80,660.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 2,042,875.3 мянган төгрөг төсөвлөгдсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор төлөвлөгөө нийт 1,851,723.1 мянган төгрөгөөр тайлагнасан нь ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс ЗДТГ 31,204.9 мянган төгрөгөөр, СӨБ 15,191.8 мянган төгрөгөөр, ЕБС 16,220.1 мянган төгрөгөөр, Эрүүл мэндийн төв 23,560.1 мянган төгрөгөөр тус тус дутуу, Соёлын төв 2,216.4 мянган төгрөг, ИТХ 667.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Нийт зардлын 1,114,427.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 777,599.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 14,272.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 66,060.9 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 80,660.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 1,817,239.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 34,283.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 200.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 1,851,723.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 29,703.9 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 35,796.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,851,723.1 мянган төгрөг буюу 90,6 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 226,659.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, Цалин, НДШ-ын зардалд 25,198.8 мянган төгрөг, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 32,473.3 мянган төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардалд 134,002.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 18,212.9 мянган төгрөг, нийт 209,887.9 мянган төгрөг зарцуулж оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 16,771.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, үлдэгдэлгүй гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баянцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-ийн санхүүгийн тайланд нийт 43,091.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9,493.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 33,506.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага бичиж, 92.1 мянган төгрөгийн шилэн дансны хуулийн хэрэгжилт, авлагатай холбоотой 2 зөрчилд зөвлөмж өгч, илэрсэн алдаа зөрчлөөс 33,506.3 мянган төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, материаллаг алдаа урьдчилан тогтоосон төвшнөөс бага байсан тул зөрчилгүй дүгнэлт өгсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Дундманхаадай аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргаж, эмийн эргэлтийн сангийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд 10,193.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 177.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 628.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,489.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 407.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1,761.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж, эмийн эргэлтийн сангийн тайланд 70,213.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Баянцогт сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 8 дугаар тогтоолоор тодотгон баталсан 2,016,461.7 мянган төгрөгийн төсвийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,066,424.8 мянган төгрөгөөр буюу ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс ЗДТГ 20,000.0 мянган төгрөгөөр, СӨБ 24,726.3 мянган төгрөгөөр дутуу, ЕБС 46,666.0 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй баталсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Аудитын код ТӨА-2022/18/НА-СТА-ТТЗ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллээс 4, 5 сарын мэдээг хугацаа хоцроож байршуулсан, 4, 5, 6, 7 сарын мэдээг өөрчлөөгүй өмнөх сарын мэдээг байршуулсан, мэдээнүүд нь өмнөх сараасаа буурсан, зөрүүтэй байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/411 дугаарын албан бичгээр ирүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад газар эзэмшүүлэх, газрын эрх шилжүүлсний орлогын албан татварыг бүрэн ногдуулж, барагдуулсан эсэхэд дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 169,318.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 143,051.7 мянган төгрөгийн албан шаардлага, 26,266.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

4.3 Албан шаардлага

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр биелүүлсэн боловч 6 нэр төрлийн албан татвар 3,8-90,2 хувиар буюу нийт 13,073.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5-д “төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 129,477.9 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй байна. Энэ нь МУЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5.2-т “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа санд байршуулсан 500.0 мянган төгрөгийг өглөг дансанд бүртгэлгүй орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “ангилал”, “эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 9,449.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайлан дах бараа материалын эхний үлдэгдэл, бараа материалын журналын эхний үлдэгдэл 3,544.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “толилуулга”, “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн үлдэгдлийг зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, бараа материал, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

2. Шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Аудитын код ТӨА-2022/18/НА-СТА-ТТЗ

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд сумын ИТХ 2 дугаар улирлын мэдээг байршуулаагүй, 6, 7 сарын мэдээг хугацаандаа байршуулахдаа, 4, 5 сарын мэдээг хугацаа хоцроож байршуулахдаа өмнөх сарын мэдээг өөрчлөөгүй, орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг мэдээлээгүй, эмийн эргэлтийн сан мэдээлбэл зохих 176 мэдээллээс 175 мэдээллийг хугацаандаа, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Засаг даргын тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллээс 4, 5 сарын мэдээг хугацаа хоцроож байршуулсан, 4, 5, 6, 7 сарын мэдээг өөрчлөөгүй өмнөх сарын мэдээг байршуулсан, мэдээнүүд нь өмнөх сараасаа буурсан, зөрүүтэй байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл “Шилэн дансны зарчим” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх

3. Татварын цахим баримттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Эмийн эргэлтийн сангийн тайлант хугацааны борлуулалтын орлогыг татварын и баримттай тулган шалгахад 13,272.9 мянган төгрөгийн орлогыг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт, борлуулалтыг татварын цахим баримтаар баталгаажуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хүснэгт 2 Алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянцогт сумын засаг дарга	9	169,318.5	0	0.0	0	0.0	4	143,051.7	5	26,266.7